

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022.06.09

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт зорилго, арга хэмжээ, "Хүний хөгжлийг дэмжих жил"-д зориулан эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулах, иргэдийн оролцоог дэмжин соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг иргэд, олон нийт, албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй хэлбэрээр хүргэж, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, сумдад бэлтгэгдсэн "Эрх зүйн хөтөч"-үүд, сумдын орон тооны бус "Эрх зүйн хөтөч" багийн ахлагч буюу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомж хэрэгжүүлэх, сурталчлан таниулах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн хариу өгөх, цаашид хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын Тамгын газрын болон хэлтсийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2022 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт,
бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид
цахим болон гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар

Тайлант хугацаанд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 439 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс шинээр 20, нэмэлт, өөрчлөлт орсон 399 хууль, Засгийн газрын тогтоол 4, УИХ-ын тогтоол 15, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 1-ийг тус тус бүртгэн санг баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт давхардсан тоогоор 5 хууль тогтоомж, хүчингүй болсон хасагдсан 76 зүйл заалтыг тухай бүр эрх зүйн ангилал хийж, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 65 иргэн, албан тушаалтанд үзүүлж үйлчилгээг хүргэлээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг
хянаж санал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны
хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу
хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны
төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 198 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулж санал авах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 205 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, зарим шийдвэрийг байгууллага, иргэдэд хуулбар хувиар хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай”, “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Сайхан-Овоо, Өндөршил сумдын “Малын тоо толгойд 2022 онд ногдуулах албан татварын хэмжээ тогтоох тухай журам”-уудыг Захиргааны хэм хэмжээний актын үлсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулахаар www.dundgovi.gov.mn цахим хаягаар иргэдээс санал, хүсэлтийг хүлээн авч төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаар “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”, “Бүрдийн уянга зусланд амрагчдын үнэ тарифыг шинэчлэн батлах тухай”, “Хүүхдийн парк”-аар үйлчлүүлэгчдийн эрхийн бичгийн үнийг шинэчлэн тогтоох тухай журам”-уудын төслийг хэлэлцүүлэн баталж улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж
буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг
арилгуулах талаар авсан арга хэмжээ

Сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2022 онд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан 411 эрх зүйн акт, сумдын төрийн байгууллагуудын дарга нараас батлан гаргасан 393 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан 427 тушаалыг хуваарийн дагуу хянаж, зөрчилтэй 243 захирамж, тушаал буюу 19.7 хувьд нь гаргасан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан талаар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэн тус хугацаанд цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгуулан, эрх зүйн сургалтыг 11 удаа 527 хүнд, сурталчилгааг 2 удаа 480 гаруй хүнд зохион байгууллаа. “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Дундговь Эрх зүйн хөтөч”, “Дундговь Насан туршийн боловсрол”, “Авлигагүй Дундговь” пэйж хуудсуудаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой аймаг, сумын эрх зүйн хөтөчүүд 106 нийтлэлийг байршуулан иргэд, олон нийтэд хүргэж, хууль, эрх зүйн туслалцаа хүссэн 125 хүнд Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн хамт хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.



➤ Аймгийн ГХУСАЗСЗ-хөтөч нарын дунд тэдний үйл олон нийтийн эрх зүйн дээшлүүлэх, багаар уралдаан зарлан, иргэд, олгох чиглэлээр “Малчдын өдөрлөг, “Гэмт хэргээс бүрт” зэрэг арга байгууллаа.



тэй хамтран сумдын Эрх зүйн ажиллагааг тогтмолжуулах, иргэд, боловсролыг тасралтгүй ажиллуулах зорилготой болзолт малчдад эрх зүйн боловсрол зөвлөгөө, “Малчны нэг өдөр” урьдчилан сэргийлэх ажлыг сум хэмжээнүүдийг хамтран зохион

➤ Төрийн болон орон нутгийн албан хаагчдад Захиргааны Авлигын эсрэг хууль, Нийтийн хувийн ашиг сонирхлыг сонирхлын зөрчлөөс урьдчилан тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах хүрээнд ЗДТГ-ын болон түүний харьяа төрийн байгууллагуудын албан хаагчид, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн аймаг, сумдын улсын байцаагчид, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн аймаг дахь салбарын албан хаагчид, УЦУОШТ-ийн нийт 150 гаруй албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой 6 удаагийн сургалтыг зохион байгуулан, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замын талаар ярилцлага, хэлэлцүүлгийг зохион байгуулав.




өмчит байгууллагын ерөнхий хууль, албанд нийтийн болон зохицуулах, ашиг сэргийлэх хууль байнга мөрдөн, Эрдэнэдалай сумын

➤ “Хүний хөгжлийг дэмжих жил”-д зориулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд бэлтгэгдсэн сумдын 60 “Эрх зүйн хөтөч” нарыг давтан сургах тус оны эрх зүйн сургалтыг танхимын хэлбэрээр 2 өдөр зохион байгуулан, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлж чадавхжууллаа. Уг сургалтад аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Сумын мэргэжилтний багийн ахлагч нар”-ыг оролцуулж, тэдний эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах ерөнхий чиг үүргээр хангаж, тусгайлсан сургалтыг хамт зохион байгуулав.



➤ Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс нээсэн “Эрх зүйн хөтөч нэгдсэн групп”, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс нээсэн “Дундговь Эрх зүйн хөтөч пэйж хуудас”, “Дундговь Эрх зүйн хөтөч” чат зэрэг цахим хуудсуудаар Эрх зүйн хөтөчүүдийг цахим хэлбэрээр арга зүйн удирдлага, мэдээллээр байнга ханган, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажилласан.



➤ “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний II шатны буюу 2020-2023 оны аймгийн төлөвлөгөө болон улсын “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний дагуу сумын ЗДТГ-ыг төлөвлөгөөндөө тодотгол хийж



хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүргүүлэн, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга буюу “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч нарт “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллах, эрх зүйн албан бус цахим сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр сургалт, сурталчилгааг хүргэх, эрх зүйн хөтөчүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, тэднийг дэмжин ажиллах талаар семинар, сургалтыг зохион байгууллаа. Энэ үеэр аймагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдын “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг 300 ширхэгийг иргэдэд хүргүүлэхээр түгээсэн.

➤ Эрх зүйн хөтөч орон тооны бус баг болон “Эрх зүйн нарын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор сумын Засаг Тамгын газрын албан хаагчдаас 2022 онд судлан сурталчлах, эрх зүйн актын хөтөлбөрийн жагсаалтыг улирал бүр 4 хууль тогтоомжоор зохион байгуулуулахаар жагсаалтыг боловсруулан хүргүүлж, хяналт тавин, сурталчлан таниулах хамтран зохион байгуулж байна.


хөтөч”
даргын
хууль,

ажлыг

➤ “Хуульчийн Про боно” өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Мандал” худалдааны төв талбайд зохион өдөрлөгийг аймгийн Засаг дарга болон хууль хяналтын байгууллагуудын удирдлагууд нээж үг хэлсэн. Өдөрлөгт даргын Тамгын газар, Монгол Хуульчдын аймгийн салбар, Хүний эрхийн үндэсний дахь салбар, Эрх зүйн туслалцааны төв, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний Өмгөөлөгчдийн зөвлөл, аймгийн танхим, Хууль, эрх зүйн хэлтэс, хяналтын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг хууль хяналтын болон төрийн 18 байгууллага оролцож, “Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл үнэ төлбөргүй өгөх”, төрийн байгууллагууд “Төрийн байгууллагын зарим иргэдийн шийдвэрлэх, холбоотой ажилласаны зүйн зөвлөгөө, хүргэн



➤ Хууль зүйн үндэсний бэлтгэн ирүүлсэн иргэдийн эрх зүйн дээшлүүлэх зорилготой бэлтгэсэн Цогоо, Ариун эрхэм нандин, Чимээгүй хөрш зэрэг 6 ширхэг киног www.dundgovi.gov.mn аймгийн Засаг даргын Тамгын хөтөч" пэйж хуудас, сум, вэбсайт болон пэйж хуудас, байрлаж буй ЛЕД дэлгэцээр сурталчлан таниуллаа.



хүрээлэнгээс мэдлэгийг Надад итгэ, Гэнэн Дуудлага, Хүү, богино хэмжээний вэбсайт, “Дундговь газар”, “Эрх зүйн байгууллагуудын аймгийн төвд улирлаар

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйл буюу аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд 2022 онд 147.585.600 сая төгрөг батлуулж, хууль сахиулах байгууллагуудын саналд үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн анхдугаар хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 40 заалттайгаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн танилцуулгыг хүргүүлж “Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг” уралдаан, “Хүүхэд хамгаалал” арга хэмжээ, “Өсвөрийн сэргийлэгч” тусгай арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс бүлгэмийн гишүүдийг энгэрийн тэмдэгжүүлэх, олон нийтийн цагдаагийн урамшуулал, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдэд 2022 оны эхний 5 сарын байдлаар 59.131.640 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санхүүжүүлж зарцуулаад байна.

2022 оны эхний 5 сард тус аймагт бүртгэгдсэн 129 гэмт хэрэгт 83 хүн холбогдсон ба эдгээрийн 87.95 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Мөн гэмт хэрэгт холбогдогчдын 69.88 хувийг эрхэлсэн тодорхой ажилгүй болон малчин иргэдээс үйлдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 48.1 хувь, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2.6 дахин, залилах гэмт хэрэг урд оны мөн үеэс 58.3 хувиар тус тус өссөн. Энэ үзүүлэлтээс харахад эрэгтэйчүүдийн гэмт хэрэгт илүү өртдөг шалтгаан нь эрхэлсэн тодорхой ажилгүй, боловсролын түвшин бага, архи согтууруулах ундааны хэрэглээ өндөр, хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй зэргээс шалтгаалж байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 8 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр буюу 11.1 хувиар буурсан, илрүүлэлт 50 хувьтай байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 5 сумдын малчдыг хамруулан малчдын зөвлөгөөнийг 1 удаа зохион, мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 1 удаа сургалт, 8 суманд зохион байгуулагдсан “Малчдын өдөр” өдөрлөгт 8 удаа яриа таниулга хийж нийт 3800 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2022 оны эхний 5 сарын байдлаар 9 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 нэгжээр буюу 50 хувиар өссөн. Цагдаагийн газраас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн арга хэмжээ 4, хэсэгчилсэн арга хэмжээг 6 зохион байгуулсан. Нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 20 удаа зохион байгуулсан.

Тээврийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион байгуулсан “Уусан бол бүү жолоод” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд мотоциклийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж хууль хяналтын байгууллагуудын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан, нийт 1.358.000 хэрэглэгчийн хандалт хийгдсэн байна.

Цагдаагийн газраас 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт 7177 зөрчилд 298.190.000 төгрөгний торгууль ногдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Эдгээр зохион байгуулсан ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сарын байдлаар хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 1.1 хувиар өссөн, үүнээс автотээврийн хулгай 50 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 11.1 хувь, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 50 хувь, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 45.5 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтэй гарав.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр

Тус аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 116 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна. 2022 оны эхний 5 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеэс 13 нэгжээр буюу 41.8 хувиар өссөн.

“Архигүй амьдралыг цогцлооё-Архигүй төрийн алба” аяны хүрээнд “Архи, согтууруулах ундааны нийгэм, гэр бүлд үзүүлэх хор нөлөө” сэдвээр сургалт мэдээлэл хийж, 1 удаагийн подкаст нэвтрүүлэг, 14 төрлийн зурагт хуудас, 2 төрлийн теле зохиомж бэлтгэн, иргэд олон нийтэд хүргэсэн. Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон 4 иргэнийг шүүхийн шийдвэр гаргуулан, архины албадан эмчилгээнд хамруулсан.

Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан архинд донтох өвчнийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаар аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар “Мэргэжилтний баг” байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр “Говийн хийморь” бүлгийн гишүүд, ахлагч нартай уулзалт ярилцлага зохион байгуулан, Сайнцагаан сумын “Говийн хийморь” АА бүлгийн 9 жилийн ойн арга хэмжээ дөрөвдүгээр сарын 24-ний өдөр болж, бүлгийн гишүүдийн уулзалт ярилцлага, “Гэгээн үдэш” цэнгүүн зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Сумын мэргэжилтний багийн ахлагч нар”-ыг оролцуулж, тэдний эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах ерөнхий чиг үүргээр хангаж, тусгайлсан сургалтыг зохион байгуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Тус аймгийн архивын тасгаас 2022 онд нөхөн бүрдүүлэлт хийх 20 хөмрөг үүсгэгчийн 1300 хадгаламжийн нэгжийг төрийн архивт хүлээн авах төлөвлөгөөг хөмрөг үүсгэгч сум, байгууллагад хүргүүлж, баримт хүлээн зөвлөмж өгч ажилласанаар 6 хөмрөгийн баримт хүлээн авсан бүртгэл, актыг хөтөлж, хөмрөгт байрлуулсан.

Шинээр ашиглалтанд оруулсан 15 өргөтгөлийн үйл ажиллагаанд улсын бүрэлдэхүүнд ажиллаж, 56 хадгаламжийн журмын дагуу хүлээн авч акт, жагсаалтыг техник технологийн цаасан болон тусгай тус тус архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн.



авах арга зүйн 270 ХН-ийг архивт зааврын дагуу

барилгын засвар, комиссын нэгжийг зохих үйлдэн зураг төсөл төрлийн баримтаар

Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 1 удаа хуралдуулж архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт зэрэг нийт 5 сум, байгууллагуудын бүртгэл жагсаалтыг хянан хэлэлцэж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж, <https://e-archives.gov.mn-ээп> тус онд байгууллага, иргэдийн нийт 29 хүсэлтийг хүлээн авч холбогдох лавлагааг тоон гарын үсгээр гаргаж онлайнаар хүргүүлсэн.

Баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 100 ширхэг хайрцаг захиалан авч 3 хөмрөгийн 4 дансны 245 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын хайрцагт хийж, заагуурыг шинэчлэв.

Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд 25 хөмрөгийн 36 дансны 700 хадгаламжийн нэгжийг цахимжуулахаар төлөвлөж ажилласнаар эхний хагас жилд 8 хөмрөгийн 300 гаруй ХН-ийн 12850 хуудас баримтыг иж бүрэн үүсгэж, цахим санд оруулан, мэдээллийн сан үүсгэсэн.

Үндэсний архивын газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн архивын баримт ыг мөрдөн ажиллаж архивын зорилгоор иргэд, шинж чанартай лавлагаа гүйцэтгэснээр 6 сарын 10-ны иргэний хүсэлтийг хүлээн авч иргэнд хувь хуулбар гарган хуулбар гаргаж үйлчилсэн. давхардсан тоогоор 2200 мэдээлэл лавлагааны ажилд ашиглууллаа.



ашиглалтын нийтлэг журам”- баримтыг ашиглуулах байгууллагын нийгэм эрх зүйн олгох ажлыг хийж байдлаар нийт 580 гаруй 135 иргэнд лавлагаа, 440 өгч, нийт 550 гаруй лавлагаа, Эдгээр лавлагаанд гаруй хадгаламжийн нэгжийг

Уншлагын танхимаар үйлчлүүлсэн 1 иргэнд 37 хадгаламжийн нэгжийг судалгаанд ашиглуулсан.

МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвтэй хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтад 3, мэргэшүүлэхийн сургалтад 5, нийт 8 албан хэрэг хөтлөлтийн ажилтныг хамруулан сургалаа.



Сум, байгууллагын хариуцсан ажилтан болон Архив, албан хэрэг хөтлөлтийн 2021 оны 246 дугаар тогтоол, бичгийн стандарт, ажиллагааны нийтлэг журам"- 24 удаа сургалт зохион 15 сум, 22 байгууллагын 310 хаагчийг хамруулсан. .



архив, албан хэрэг хөтлөлт төрийн албан хаагч нарт тухай хууль, Засгийн газрын 2011, 2021 оны Баримт "Байгууллагын үйл

аар нийт байгуулж, албан

Архивын тасгийн үйл сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор тус тасагт төхөөрөмжийн хангалт болон баримтын хадгалалт хамгаалалт, хадгаламжийн сангийн аюулгүй зориулж нийт 5,350,000 төгрөгийн баримт хадгалах зориулалтын 2 нягтруулсан шүүгээ, хадгаламжийн 2 хяналтын камер, хурдны скайнер зэргээр ханган, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулсан.



ажиллагааг тоног хадгалалт байдалд

санд баримтын

Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх хүрээнд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллалаа. Үүнд:

Цагдаагийн газрын үйл ажиллагаанд чанарын менежмент ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх, баталгаажуулалтын аудитын зардалд зориулан 3 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэрлэсэн.

Цагдаагийн газрын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 26 ширхэг богино долгионы радио холбооны хэрэгслээр хангасан.

Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1 га газрыг шийдвэрлэн төмс, хүнсний ногоо, жимсний мод тариалах, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хүндэтгэлийн "Сүлд" талбайн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлж газрын асуудлыг тус тус шийдвэрлэсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйдийн 94.1 дэх хэсэг, Засгийн газрын 1992 оны 43, 2000 оны 94 дүгээр тогтоолын дагуу цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангах, хэсгийн байрны үйл ажиллагааны урсгал зардлыг шийдвэрлэхэд анхаарч, 6 сумын халаалтын зардлыг орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагч болон хоригдогч, хоригдлын аюулгүй байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорих байранд телекамер бүхий домофон системийг нэвтрүүлэхээр төлөвлөн 25.4 сая төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэн тендер зарлагдсан ба 2022 оны 06-р сарын 13-ны өдөр тендерийн материалыг хүлээн авч шалгаруулах ажил зохион байгуулагдана.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын аймаг дахь салбартай хамтран эхний хагас жилд 14 удаа, 417 иргэнд хүний эрхийн талаарх эрх зүйн сургалтыг зохион байгууллаа. Хүний эрхийн асуудлаар нийтдээ 26 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүллээ. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой 2 гомдлыг хүлээн авч, нэг гомдолд ажиллагаа хийн ажиллаж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 7 газар буюу Цагдаагийн газрын саатуулах, эрүүлжүүлэх байр болон аймгийн төвийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургууль, хөдөөгийн сумд болох Өндөршил, Гурвансайхан, Хулд, Луус сумын дотуур байруудад хяналт шалгалт зохион байгууллаа.

Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжин, иргэдэд үйлчилгээ үзүүлэх өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчин нөхцлийг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газраас бүрэн хариуцан, хэвийн ажиллуулж байна. Тус хугацаанд эрүүгийн 34 хэргийн төлбөрийн чадваргүй 39 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 170 иргэнд үзүүллээ.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

/С.ЦЭНГЭЛМАА/

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

/Л.БАЯРСАЙХАН/

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл” сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	439	439
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо			439	439
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	1	1
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	399	399
		Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	774	45	819
			Байгууллага	21	20	41
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	386	215	601
			Байгууллага	25	25	50
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		411	198	609
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн	2	5	7
			Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	1	1
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		118	11	129
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		6736	527	7263
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		312	2	314
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		25төрөл/ 1933	2 төрөл/ 300	27төрөл/ 2233
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг		40	14	54

		Сонин хэвлэлээр сурталчилсан	203	2	205
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан	640	2	642

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.ЦЭНГЭЛМАА/

МЭДЭЭГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА /Л.БАЯРСАЙХАН/